

ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ УЛААНБААТАР ХОТНОО БОЛНО

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын яам, ШУА, ОХУ-ын Цөмийн шинжилгээний нэгдсэн институт, БНСУ-ын Инчеоны их сургуулийн хамтарсан **“Modern trends in natural science and advanced technologies in science education”** олон улсын эрдэм шинжилгээний хурлыг 2018 оны 8 сарын 20-24-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулах гэж байна. Эрдэм шинжилгээний хурал нь олон улсын эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургуулиуд хоорондоо туршлага солилцох, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, залуу эрдэмтэн судлаачдад судалгааны ажлаа танилцуулах, хэлэлцүүлэх, шинэ санаа, судалгааны арга зүйг солилцох зэрэг өргөн хүрээг хамарч байгаагаар онцлог юм.

Энэхүү эрдэм шинжилгээний хурлаар дараах сэдвүүдээр илтгэл хэлэлцэнэ. Үүнд:

- Боловсрол ба шинжлэх ухаан нь иноваци, эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөөлөл
- Математик инженерийн боловсрол болон шинжлэх ухаан технологийн асуудлууд
- Боловсрол, шинжлэх ухаан дахь орчин үеийн технологиуд
- Сэргээгдэх эрчим хүчний асуудлууд: шинжлэх ухаан, боловсрол ба технологи
- Мега төслүүд ба хүний нөөцийн хөгжил

- Виртуал шинжлэх ухааны лабораториуд
- Олон улсын сургалтын төвүүдийн үүрэг ба түүний хөгжилд оруулах хувь нэмэр

Хурлын үеэр эрдэм шинжилгээний ажлын үр дүн, шинэ технологийг танилцуулах үзэсгэлэн зохион байгуулах юм. Олон улсын эрдэм шинжилгээний хуралд БСШУС-ын сайд Ц.Цогзолмаа, ШУА-ийн Ерөнхийлөгч академич Д.Рэгдэл, ОХУ-ын Боловсрол шинжлэх ухааны яамны дэд сайд академич Г.В.Трубников, Цөмийн шинжилгээний нэгдсэн институтын захирал, академич В.А.Матвеев, БНСУ-ын Инчеоны их сургуулийн захирал, профессор Донг Сунг Чо нар үндсэн илтгэл хэлэлцүүлэхээс гадна, Франц, Япон, Австри улсын их дээд сургуулиудын багш, профессорууд урилгаар оролцож, илтгэл хэлэлцүүлнэ. Хурлын бүртгэл, илтгэлийн хураангуйг хүлээн авах хугацаа 6 дугаар сарын 20-ны өдөр дуусна.

Олон улсын эрдэм шинжилгээний хурлын өгүүлэл нь ШУА-ийн “Proceedings of the Mongolian Academy of Sciences” сэтгүүлд нийтлэгдэх юм.

Хурлын танилцуулга, эрдэм шинжилгээний өгүүллэгийн формат болон бусад дэлгэрэнгүй мэдээллийг <http://nsse2018.ac.mn> цахим хуудаснаас сонирхоно уу!

МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ